

ТАНИЛЦУУЛГА

2018 оны 2 дугаар улиралд Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгт хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тухай

2018.06.22

Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгт хандан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ холбогдох албан тушаалтнууд “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол улсын хууль, Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 67-р тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон амаар, бичгээр, 7059106 утсаар, цахимаар болон боломжит бүхий л хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн явцыг тухай бүр Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн удирдлагуудад танилцуулан ажиллаж байна.

2018 оны 2-р улиралд иргэдээс амаар, бичгээр, утсаар нийт 21 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 21 өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн нь 100%-ийн үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн газар: 2018 оны II улирлын байдлаар Эрүүл мэндийн газарт ЗГ-ын 11 11 төв, 7059106 ирсэн эмийн хөнгөлөлттэй холбоотой, Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төвийн даргатай холбоотой 2 гомдлыг бүртгэн авч шийдвэрлэн ажилласан. Мөн бичгээр ирсэн Эрдэнэдалай сумын сум дундын эмнэлгийн мэс заслын эмчийн Нэгдсэн эмнэлэгт ажиллах хүсэлт гаргасан өргөдлийн хүлээн авч судлан хариу тайлбар хүргүүлэн ажиллаа.

Нэгдсэн эмнэлэг: Иргэдийн тавьсан санал, хүсэлт шүүмжлэлийг шийдвэрлэх талаар авсан арга хэмжээ, өргөдөл гомдол шийдвэрлэх тушаалын хэргэжилтийг хангаж иргэдээс гарсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх арга хэмжээг авч зохион байгуулсан ажлын талаарх мэдээг холбогдох газарт хугацаанд нь тайлагнаж мэдээллийн самбарт тавьж танилцуулж байна.

- ✓ Дотор, мэдрэлийн тасагт үйлчлүүлэгч олон байгаагаас орны хүлээгдэл байнга байсан. Үйлчлүүлэгчдийн биеийн байдалд эрэмбэлэн ангилалт хийж

захиалсан хугацаанаас өмнө хэвтэх шаардлагатай 2 хүнийг дотор, мэдрэлийн тасагт хэвтүүлсэн. 3 үйлчлүүлэгчийг орны дугаарын дагуу ирж хэвтэх талаар тайлбарлан тухайн өргөдлийг шийдвэрлэсэн.

- ✓ Эмнэлэгт хугацаандаа хэвтэж чадахгүй байна гэсэн өргөдлийг 4 удаа ирүүлсэн 1 үйлчлүүлэгчийг дотрын тасагт хэвтүүлсэн.
- ✓ Дугаар олгох техникийн сааталыг засварлаж дахин дараалал үүсгэхгүй болгосон.
- ✓ Төрөх тасагт үйлчлүүлсэн эмэгтэй эмнэлгээс өөрийн хүсэлтээр урьдчилан гарахыг хүссэж, эмнэлгийн мэргэжилтэнтэй зөрчилдснөөс үүссэн гомдлыг барагдуулж, уг үйлчлүүлэгчдэд эмнэлгийн үйлчилгээний журмыг тайлбарлан, эмчилгээний зөвлөгөө өгч эмнэлгээс гаргасан.
- ✓ Тендерийн эмийн тасалдалтаас эм захиалагдаж ирээгүйн улмаас тухайн үйлчлүүлэгчийн эм тасарсан, гаднаас авч хэрэглэснийг эмийн үнийг эргүүлэн олгосон.
- ✓ Поликлиникийн дотрын кабинетийн эмчийн ажлын цагийн хоцрогдолтын талаар өөрт нь анхааруулж, үйлчлүүлэгчдэд чирэгдэл учруулахгүй байх талаар анхааруулсан.

Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчидтэй харилцах горимыг баримтлаж ажиллах, үйлчлүүлэгчдэд бүрэн үзлэг хийж эмнэлгийн дүгнэлтийн хуудсыг бөглөж байх талаар зөрчил гаргасан эмнэлгийн мэргэжилтэнд анхууруулсан.

ТАЙЛАН ГАРГАСАН: ЭМГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

ТАЙЛАНГ ХЯНАСАН: ЭМГ-ЫН ДАРГА

О. ЭНХЦЭЦЭГ

Г.БАТ-ОРШИХ

